



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ИЛ ТАЙЛАГНАЛЫГ САЙЖРУУЛАХ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

2024 оны 8 дугаар сар

Агуулга

1. Ерөнхий мэдээлэл.....	3
Тулгарч буй асуудал.....	3
Зөвлөмж	4
2. Замын зураглал.....	5
АЛХАМ 1. Олон талт оролцогчидтой хамтран ажиллах нь.....	5
АЛХАМ 2. Датаг нэгтгэх, хялбаршуулах нь	7
АЛХАМ 3. ОУИТБС-ын тайланг сайжруулах нь	8
АЛХАМ 4. ТӨК-ийн мэдээллийн чанарын хяналтыг дээшлүүлэх нь	8

Хавтасны зураг: Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн

1. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит компаниудын ил тайлагналыг сайжруулах төлөвлөгөө буюу замын зураглалыг энэ тайланд танилцуулж байна. Энд зөвлөж буй арга хэмжээг Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит компани (ТӨК)-ийн олон улсын болон дотоодын стандартын хүрээн дэх ил тайлагналын нөхцөл байдлын талаар хийсэн судалгааны үр дүн, зөвлөмжид үндэслэн боловсруулав. Уг нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэг, санхүүжилтээр Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн гүйцэтгэсэн болно.

Тулгарч буй асуудал

Нөхцөл байдлыг тодорхойлох судалгаагаар Монгол Улсын уул уурхайн ТӨК-ийн ил тайлагналын асуудалд дараах сорилтууд тулгарч байна гэж дүгнэсэн. Үүнд:

- **Мэдээлэл зөрүүтэй эсвэл бүрэн бус:** ТӨК-ийн тухай нэг төрлийн мэдээлэл (жишээлбэл, ТӨК-ийн тоо, төрийн эзэмшлийн хувь хэмжээ гэх мэт) нь эх сурвалжаас хамаараад зөрүүтэй эсвэл дутуу байгаа нь мэдээллийн үнэн зөв байдалд нөлөөлж, мэдээлэлд үндэслэн бодлогын шийдвэр гаргахад саад болж байна.
- **Мэдээллийн чанар жигд бус:** ОУИТБС нь олон төрлийн мэдээлэл цуглуулдаг боловч чанар болон иж бүрэн байдал нь мэдээллийн төрөл, компани тус бүрээр ялгаатай байна. Татвар, төлбөрийн мэдээлэл ихэнх тохиолдолд чанартай байхад бенефициар өмчлөгч, бүтээгдэхүүний борлуулалт гэх мэт бусад мэдээллийн чанар, нарийвчлал нь хангалтгүй түвшинд байна. ОУИТБС-ын нэгтгэл тайланд төлбөрийн бус мэдээллийн чанарын талаар дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийдэггүй.
- **Мэдээллийн сан хооронд өгөгдөл солилцдоггүй:** Мэдээлэл, тоо баримт нийтэлдэг Засгийн газрын болон бусад этгээдийн сангууд нь хоорондоо холбогдож мэдээлэл солилцдоггүй, салангид байдлаар ажиллаж байна. Жишээлбэл, Шилэн дансны мэдээллийн портал нь ТӨК-тай холбоотой үнэ цэнэтэй мэдээллийг нийтэлдэг ч ОУИТБС-ын болон засгийн газрын бусад мэдээллийн сантай өгөгдөл солилцдоггүйгээс гадна бүх хэлбэрийн ТӨК-ийг хамардаггүй байна.

Монгол Улсын төрийн өмчит компанийн ил тайлагналыг сайжруулах замын зураглал

- **Нээлттэй өгөгдлийн хэлбэрээр нийтэлсэн мэдээлэл хомс:** Шилэн данс зэрэг хэд хэдэн эх сурвалжид байдаг ТӨК-ийн мэдээллийг нээлттэй, компьютерээр унших хэлбэрээр нийтлэхгүй байна (жишээ нь санхүүгийн тайланг нээлттэй өгөгдлийн форматаар бус, зурган файлаар нийтэлдэг).
- **ТӨК-ийн тайлагнах стандартын тухай яриа хэлэлцүүлэг хангалтгүй:** Монголын ОУИТБС нь тус санаачилгын 2023 оны стандартын дагуу ТӨК-ийн заавал болон сайн дураар тайлагнах зарим шаардлагыг хангаж чадахгүй байна. Хэдийгээр ОУИТБС-ын тухай хуулийн төсөл нь боломж мөн боловч энэ асуудлыг хөндөх өөр бусад талбарууд ч байгаа.

Зөвлөмж

Нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа нь ОУИТБС-д оролцогч талуудад зориулж дараах зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

- **Олон талт оролцогчдыг татан оролцуулах:** Судалгааны үр дүнг хэлэлцэж, ОУИТБС-ын авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийн замын зураглал боловсруулах асуудлаар Олон талт оролцогчдын бүлгийн гишүүдтэй уулзалт зохион байгуулах.
- **Мэдээлэл буюу датаг нэгтгэх, хялбаршуулах:** Мэдээлэл буюу дата цуглуулах, тайлагнах, солилцох асуудлыг жигдлэх, хялбаршуулах асуудлаар Сангийн яам (Шилэн дансны мэдээллийн сан), татварын алба, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол нэгдэлтэй уулзалтууд зохион байгуулах.
- **ОУИТБС-ын тайланг сайжруулах:** Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй бүх ТӨК тайланг бүрэн бүтэн, үнэн зөв, хугацаанд нь илгээх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ОУИТБС-ын тайлангийн маягт, онлайн системийг сайжруулах зөвлөмжийг боловсруулах.
- **ТӨК-ийн мэдээллийн чанарын хяналтыг дээшлүүлэх:** ТӨК-тэй холбоотой мэдээллийн чанарт онцгой анхаарал хандуулах чиглэлд ОУИТБС-ын нэгтгэл тайланг боловсруулдаг зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг шинэчлэх.

Монгол Улс ТӨК-ийн ил тайлагналыг сайжруулах асуудлаар олон санаачилга хэрэгжүүлж байгаа хэдий ч шийдвэрлэх асуудал, бэрхшээл нэлээд байна. Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх

нь ТӨК-ийн ил тод тайлагналыг цогц байдлаар шинэчлэх, ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангах, олон нийтийн итгэл, эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхэд нэн чухал юм.

2. Замын зураглал

Энэ хэсэгт Засгийн газар болон Олон талт оролцогчдын бүлэг хамтарч Монгол Улсын ТӨК-ийн ил тайлагналыг сайжруулахын тулд хэрэгжүүлэх ажил, замын зураглалыг танилцуулж байна.



АЛХАМ 1. Олон талт оролцогчидтой хамтран ажиллах

ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг нь нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны үр дүнг хэлэлцэх, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий замын зураглал боловсруулах зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах нь зүйтэй.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь нөхцөл байдлыг тодорхойлох судалгаанд дурдсан ТӨК-ийн ил тайлагналыг сайжруулах тодорхой сэдвийн хүрээнд өндөр түвшний дугуй ширээний цуврал хэлэлцүүлэг зохион байгуулах
 - Хэлэлцүүлэг бүрт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сангийн яам, Эрдэнэс Монгол нэгдлийн төлөөллийг багтаасан гол оролцогчдыг урих.
 - Хэлэлцүүлгээр дараах асуудлын хүрээнд шийдэл эрэлхийлэх:

Монгол Улсын төрийн өмчит компанийн ил тайлагналыг сайжруулах замын зураглал

- ОУИТБС-ын стандартын хүрээнд шаарддаг бүх мэдээллийг бүрэн цуглуулахын тулд ОУИТБС-ын тайлангийн маягтын өөрчлөх. Жишээлбэл, ТӨК-ийн тээврийн үйл ажиллагаа, гэрээний ил тод байдал, хүлэмжийн хий ялгаруулалт, ТӨК болон тэдгээрийн харилцагч, ханган нийлүүлэгч компанийн бенефициар өмчлөгчийн мэдээлэл, жендерт суурилсан цалингийн ялгаа зэрэг сэдвийг ОУИТБС-ийн тайлангийн маягтад нэмэх нь зүйтэй.
- Өмчлөлийн хэлбэр, хууль эрх зүйн бүтцээс гадна хамрагдах хүрээг тодорхойлох материаллаг босгыг бууруулах зэрэг асуудлыг харгалзан үзэх замаар ОУИТБС-ын тайлан, нийтэд нээлттэй мэдээллийн хувьд ашиглах ТӨК-ийн тодорхойлолтыг тодорхой болгох. Ингэснээр бүрэн, байнга шинэчлэгддэг ТӨК-ийн жагсаалтыг боловсруулах боломж бүрдэнэ.
- ТӨК-ийн харилцагч, ханган нийлүүлэгч компанийн эцсийн өмчлөгч гэх мэт зарим мэдээллийн чанарыг сайжруулахад анхаарлаа хандуулж, ОУИТБС-ын нэгтгэл тайланг боловсронгуй болгох.
- ОУИТБС-ын бүх үйл ажиллагаанд томоохон ТӨК-ийн төлөөллийн оролцоог хангах, үүнд ялангуяа Эрдэнэс Монгол, түүний харьяа компаниудыг оролцуулах, сайн дураар тайлагнадаг шаардлагын биелэлтийг үлгэрчлэн түүчээлэх нөхцөлийг бүрдүүлэх.
- ТӨК-ийн аудитын тайланг бүрэн нийтэлдэг болгох
- Баялгийн сангийн ил тод байдал, хяналт, ТӨК-ийн харилцагч, ханган нийлүүлэгч компанийн эцсийн өмчлөлийн тухай мэдээллийг ил тод нийтлэх зорилготойгоор ОУИТБС-ын мэдээллийг бусад тайлангийн системтэй холбох боломжийг эрэлхийлэх.
- Хүлэмжийн хийн ялгаруулалтын чиглэлээр тайлагнах туршлагатай компаниудтай мэдлэг солилцох. Ингэснээр бүх гол компаниуд ийм мэдээлэл цуглуулж, тайлагнах бөгөөд засгийн газар болон салбарын холбогдох мэдээллийг төрөл бүрийн эх үүсвэрээс цуглуулан нийтлэх нийтлэг үйл явцтай ОУИТБС-ын мэдээллийг уялдуулах боломж бүрдэнэ.

Монгол Улсын төрийн өмчит компанийн ил тайлагналыг сайжруулах замын зураглал

- Олон талт оролцогчдын бүлэг нь тогтсон ажлыг хэрэгжүүлэх зорилгоор арга хэмжээ, хугацаа, хариуцах байгууллагыг тодорхойлсон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах. Үүнд Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах төлөвлөгөө багтах бөгөөд ТӨК-ийн авилгын эсрэг бодлогыг боловсруулах, нийтлэх, хэрэгжүүлэхээс гадна ТӨК-тай холбоотой ОУИТБС-ын 2023 оны стандартын өөрчлөлт (төсвийн шинжтэй зардал, баялгаар баталгаажсан зээлийг хянах г.м.)-ийг мөрдөж буй эсэхийг хянах журмыг боловсруулах нь зүйтэй.

АЛХАМ 2. Өгөгдлийг нэгтгэх, хялбаршуулах

Олон талт оролцогчдын бүлэг нь мэдээлэл буюу өгөгдөл цуглуулах, тайлагнах, солилцох асуудлыг жигдлэх, хялбаршуулах асуудлаар Сангийн яам (Шилэн дансны мэдээллийн сан), татварын алба, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол нэгдэлтэй уулзалт зохион байгуулах хэрэгтэй.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь Сангийн яам, Татварын ерөнхий газар зэрэг холбогдох талуудын төлөөлөл бүхий дэд ажлын хэсэг байгуулах.
- Дэд ажлын хэсэг нь мэдээллийн чанарыг сайжруулах, тайлан бэлтгэхэд компаниудад тулгардаг дарамтыг багасгах зорилгоор Сангийн яам, Татварын алба, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол нэгдэлтэй хамтарч ОУИТБС-ын цахим систем Шилэн данстай автоматаар мэдээлэл солилцох болгох талаар хамтран ажиллах.
- Олон талт оролцогчдын бүлэг нь Шилэн дансанд нийтэлсэн, нэг эсвэл хоёр уул уурхайн ТӨК-ийн тайлангийн сайн жишээг олж, мэдээллийг вэбсайтдаа тогтмол бөгөөд системтэйгээр ил тод нийтэлдэг сайн туршлагын талаарх баримтыг ОУИТБС вэбсайт дээр нийтлэх.
- Олон талт оролцогчдын бүлэг нь Эрдэнэс Монгол нэгдэлтэй хамтарч, Эрдэнэс Силвер болон Эрдэнэс Монгол нэгдэлтэй холбоотой баялгаар баталгаажсан зээлийн үндсэн нөхцөлийг тодорхойлох (үүнд төсвийн шинжтэй зардлыг мөн багтаах), хураангуй бэлтгэх. Уг баримт бичгийг Эрдэнэс Монгол нэгдлийн болон ОУИТБС-ын вэб дээр давхар нийтлэх нь зүйтэй.

АЛХАМ 3. ОУИТБС-ын тайлагналыг сайжруулах

Олон талт оролцогчдын бүлэг нь уул уурхайн ТӨК-ийн тайланг дэлгэрэнгүй, үнэн зөв, хугацаанд нь цуглуулах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ОУИТБС-ын тайлангийн маягт, цахим системийг сайжруулах зөвлөмж боловсруулах хэрэгтэй.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын стандартын дагуу бүх ТӨК-ийг хамруулахын тулд тайлангийн маягтыг шинэчлэх зөвлөмжийг боловсруулах.
- ОУИТБС-ын Ажлын алба нь ТӨК-ийн тайлангийн шинэ маягтыг батлуулахаар Үндэсний статистикийн хороонд илгээх.
- ОУИТБС-ын Ажлын алба нь тайлангийн шинэ маягтыг бөглөх, ТӨК-д зориулсан дэлгэрэнгүй, тодорхой удирдамжийг боловсруулах.
- ОУИТБС нь тайлан бэлтгэх үүрэгтэй ТӨК-ийн менежерүүдэд зориулсан чадавхи бэхжүүлэх арга хэмжээг санал болгох.
- ОУИТБС нь бүх ТӨК-ийг Шилэн дансны мэдээллийн санд тайлагнахыг дэмжих. Ялангуяа хууль тогтоомжийн дагуу Шилэн дансанд нийтлэх шаардлагагүй байдаг, төрийн өмчийн оролцоотой ТӨК-ийг Шилэн дансанд тайлагнахад онцгой анхаарах.

АЛХАМ 4. ТӨК-ийн мэдээллийн чанарын хяналтыг дээшлүүлэх

Олон талт оролцогчдын бүлэг нь ТӨК-тэй холбоотой мэдээллийн чанарыг сайжруулахын тулд ОУИТБС-ын нэгтгэл тайланг боловсруулдаг зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг шинэчлэх шаардлагатай.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын нэгтгэл тайланг боловсруулах ажлын даалгаврыг шинэчлэх. Шинэчилсэн ажлын даалгавар нь ТӨК-ийн мэдээллийн чанарын хяналтыг сайжруулах буюу гэрээ, гэрээний нэмэлт өөрчлөлт, ТӨК-ийн харилцагчдын эцсийн өмчлөл, төсвийн шинжтэй зардлын талаар нийтэлсэн мэдээллийг нягталдаг журмыг нэвтрүүлэхэд анхаарах юм.

Монгол Улсын төрийн өмчит компанийн ил тайлагналыг сайжруулах замын зураглал

- Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС, бусад эх сурвалжид нийтэлсэн мэдээллийн чанар доголдож буй нөхцөл байдлыг тодорхойлж, эдгээр зөрчил, доголдлыг арилгахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон тэдгээрийн үр нөлөөг тайлбарлах.